

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2026 ОНЫ 05 САРЫН 05 ӨДРИЙН 04 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2026.06.25

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 05 сарын 05 өдрийн 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:

1. Эмнэлгийн ажилтны гарын ариун цэвэр сахих нөхцөл, бололцоог (угаалтуур, саван, антисептик уусмал) бүрэн хангах, ажилтны гарын ариун цэвэр сахилтад тогтмол хяналт тавьж, дүн шинжилгээ хийх
 - Нийт 9 ариун цэврийн өрөөтэй бөгөөд үүнээс эрэгтэй 4, эмэгтэй 4, мөн хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулсан 1 ариун цэврийн өрөөтэй. Эрэгтэй ариун цэврийн өрөөнд нийт 10 суултуур, эмэгтэй ариун цэврийн өрөөнд нийт 10 суултуур байрласан.
Ариун цэврийн өрөө бүр гар угаах нөхцөлөөр бүрэн хангагдсан.
 - ЭМС-ын тушаал, гар угаалт, гар угаах 5 мөчийн талаарх ажлын байрны сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 58 эмч, эмнэлгийн мэргэжилтэн гар угаалтыг UV light ашиглан шалгасан. Төвийн ажиллагсдын дотоод группд гар угаах дэлхийн өдрийн мэдээлэл, гар угаах бүжгийн бичлэг хийж байршуулж ажилласан.
 - Монголын сувилагчдын нийгэмлэг, ХБНГУ, НЭМГ-тай хамтарсан “Халдварын сэргийлэлт хяналт” сургалтыг 2026.06.22-25 хооронд зохион байгуулсан. Сургалтад:
 - Орчны халдваргүйтгэл
 - Гар угаах, халдваргүйжүүлэх
 - Хамгаалах хувцас хэрэгсэл зэрэг сэдвээр дадлага сургалт хийсэн.



2. Байгууллагын орчинд халдвар тархахаас сэргийлэх, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, бууруулах арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулах
 - ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ, НЭМҮТ-ээс гаргасан улаанбурхан өвчнөөс сэргийлэх зөвлөмж, дархлаажуулалтад хамрагдах зөвлөмж, видео контентуудыг нийт 10 удаа ЦССҮТ-ийн нийт ажиллагсдын дотоод группт байршуулж, ажиллагсдыг мэдээллээр хангаж ажилласан.
 - “Улаанбаатар ариутгал” ХХК-тай 2026.05.26-ны өдөр үйлчилгээ гэрээ байгуулж Баянзүрх цус цуглуулах төв, Сүхбаатар цус цуглуулах төвийн нийт 2233.6м² талбайд халдваргүйтгэл, шавж, мэрэгчгүйтгэл хийж гүйцэтгэлээ.



3. Цус, цусан бүтээгдэхүүн авах, бэлтгэх, тээвэрлэх стандартыг мөрдөж байгаа эсэхэд хяналт, үнэлгээг бодитойгоор хийж үр дүнг тооцох
 - Төвийн хэмжээнд сувилахуйн чиглэлээр мөрдөж буй журам, САЗ, ТТАЗ, ХХ, маягт бүртгэлийн сургалтын төлөвлөгөөг албаны даргаар батлуулан эхний хагас жилийн байдлаар САЗ, ТТАЗ, ХХ, маягт бүртгэлийн сургалтыг хуваарийн дагуу 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 35 сувилагч тусгай мэргэжилтнүүдийг хамруулсан байна.
 - Сувилагч, тусгай мэргэжилтний ижил мэргэжилтний үнэлгээг албуудын ахлах нартай хамтран 3 удаа 22 сувилагч тусгай мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан үнэлгээний нийт дүн 92% байна. Үүнд: САЗ-ыг тогтмол мөрдөх, танин тодруулалтыг хийхдээ өөрөөр нь хэлүүлэх, баримтжуулалт, ажилбар хоорондын гарын халдваргүйжүүлэлт зэрэг сайжруулах 4 саналыг албуудад хүргүүлсэн.
4. Гар халдваргүйжүүлэх уусмал, гарын цаасан арчуур, нэг удаагийн хэрэглэх хэрэгсэл (бээлэг, маск зэрэг)-ээр алба, нэгжүүдийг тасралтгүй хангаж ажиллах

- 2026 онд хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисыг худалдан авах, нийлүүлэх гэрээг нийт 5 байгууллагатай хийж халдварын сэргийлэлт хяналтад шаардлагатай бараа материалын нөөцийг бүрдүүлж ажилласан. Эхний хагас жилийн байдлаар 6 сарын нөөцтэй байна.

Хамгаалах хувцас хэрэгсэл халдваргүйтгэлийн бодисын нөөц

№	Материал	х.нэгж	Эцсийн үлдэгдэл
			Тоо
1	DesNet+, 5L can	ш	1.00
2	Аниос гел 500 мл ш	ш	25.00
3	Аюулгүйн хайрцаг 3л	ш	244.00
4	Аюулгүйн хайрцаг 5л	ш	844.00
5	Жилью 500гр	ш	1.00
6	Маск 1 удаагийн-35130	ш	5,000.00
7	Нүүрний хамгаалалт	ш	671.00
8	Нэг удаагийн комбинзон тусламж	ш	36.00
9	Нэг удаагийн малгай ш	ш	300.00
10	Нэг удаагийн маск	ш	10,631.00
11	Нэг удаагийн улавч	хос	3,750.00
12	Үзлэгийн бээлий М	ш	1,800.00
13	Халад 1 удаагийн ш	ш	3,626.00
14	Хамгаалалтын нүдний шил	ш	1,835.00

ТАЙЛАН БИЧСЭН:

ТҮЧАБА-НЫ СУВИЛАХУЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ж.НАРМАНДАХ